

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 05 сарын 13 өдөр

Дугаар A/17

Арвайхээр сум

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн A/177 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас хамгаалах "Команд штабын сургууль" зохион байгуулахтай холбогдуулан 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 09 цагаас 15-ны өдрийн 17 цаг хүртэлх хугацаанд аймгийн Эрүүл мэндийн салбарыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд байгууллагууд гамшгаас хамгаалах төлөвлөгөөнийхөө бэлэн байдлыг үнэлэн, тодотгол хийж ажиллахыг Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хархорин сумын Нэгдсэн эмнэлгийн захирал, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

3. Өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд Аймгийн Эрүүл мэндийн албаны Шуурхай штаб, салбар дундын хамтарсан Тохиолдлын удирдлагын багийг 24 цагийн бэлэн байдалд ажиллуулахыг багийн ахлагч нарт үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллахыг ажиллагааны багийн ахлагч (Ю.Ичинноров)-т даалгасугай.

5. Команд штабын сургуулийн хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудын барилга, автомашин, шатахуун, ор, эм, лабораторийн шинжилгээний урвалж, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүнсний нөөцийн судалгааг гаргаж, цагийн байдалд тохируулан төлөвлөж, зарцуулахыг Санхүү, нөөцийн багийн ахлагч (Б.Валя), төлөвлөлтийн багийн ахлагч (С.Дуламсүрэн), Эрүүл мэндийн байгууллагуудын нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

6. Нөхцөл байдлын мэдээг эрүүл мэндийн байгууллагуудаас авч, хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг өдөр бүр 10:00, 16:00 цагт Эрүүл мэндийн газрын Шуурхай штабт нэгтгэн танилцуулж байхыг хэвлэл мэдээлэл, эрсдэлийн харилцаа холбооны багийн ахлагч (Ц.Рэгзэдмаа)-т үүрэг болгосугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг штабын дарга (М.Золзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Н. ОЮУНТУЯА

Ө.Мү.Дод.Тушаал: EMC
622001964